# Улаанбаатар Олон Улсын Марафон 2019

# Улаанбаатар Олон Улсын Марафон 2019

**2019 оны 05 сарын 18 өдөр, Бямба гараг**

## Ерөнхий Мэдээлэл


**Утас: 976-7000-9809**
**info@ulaanbaatarmarathon.mn**
www.ulaanbaatarmarathon.mn
**Монголын үндэсний олимпийн хороо, 1 давхар, 110 тоот**

## Агуулга


1. Монголын хэт холын марафон гүйлтийн холбоо
2. Удирдан зохион байгуулагч нарын мэдээлэл
3. Тэмцээний огноо
4. Байршил
5. Ерөнхий зохион байгуулагч
6. Үйл ажиллагаа
7. Газар & цаг
8. Зам хаах цаг
9. Бүртгүүлэх & Бүртгэлийн хураамж
10. Тэмцээний зохион байгуулалт
11. Шагнал
12. Тэмцээний цагийн хуваарь
13. Авчрах шаардлагатай зүйлс /цаг агаараас шалтгаалан/
14. Дүрэм
15. Даатгал
16. Хувийн эд зүйлсээ хадгалуулах
17. Цаг агаар
18. Санамж & Анхааруулга
19. Нэмэлт аяллын багц
20. Тэмцээний газрын зураг
21.


1. **<u>МОНГОЛЫН ХЭТ ХОЛЫН МАРАФОН ГҮЙЛТИЙН ХОЛБОО</u>**

Монголын үндэсний олимпын хороо, 1 давхар, 110 тоот
Телефон/Такс: 976-70009809, 976-95959809
Фэйсбүүк: Mongolian UltraMarathon
Имэйл: info@ulaanbaatarmarathon.mn
www.ulaanbaatarmarathon.mn
www.mumf.org.mn
www.mongolianultramarathon.com

## 2. УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ НАРЫН МЭДЭЭЛЭЛ

**Нийслэлийн спорт хорооны нийтийн биеийн тамир хариуцсан хэлтсийн дарга:** А.Болдмаа
**Утас:** 976-11-312785
**Имэйл:** altan.boldmaa22@gmail.com

**Тэмцээний удирдагч:** С. Өнөрбаяр
**Утас:** 976-95959809
**Имэйл:** unurbayar@mumf.org.mn

**Нарийн бичиг:** Г.Цэвээнпүрэв
**Утас:** 7000-9809
***Имэйл:*** info@mumf.org.mn

**Бүртгэлийн ажилтан:** Г.Болормаа
**Утас:** 976-*88559816*
***Имэйл:*** info@ulaanbaatarmarathon.mn

## 3. ТЭМЦЭЭНИЙ ОГНОО

- ✓ 2019.05.18.Бямба гарагийн 10:00 цагаас 17:00 цагийн хооронд

## 4. БАЙРШИЛ

- ✓ Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай

## 5. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

1. Нийслэлийн засаг даргын тамгын газар
2. Нийслэлийн спорт хороо
3. Монголын хэт холын марафон гүйлтийн холбоо

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ✓ 6 дахь удаагийн Улаанбаатар Олон Улсын Марафон 2019
- ✓ Марафоны төрөл: 42км, 21км, 10км, 5000м, 1500м/гэр бүл/, 1500м/хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ зай

## 7. ГАЗАР & ЦАГ

- ✓ Эхлэх цэг: Сүхбаатарын талбай
- ✓ Эхлэх цаг: 5 сарын 18 өдрийн 10:00 цагт
  Бөөн гараа: 42км195м, 21км097м, 10км
  1500м-н гэр бүлийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөл марафон гүйлтийн явцад 5км, 10км, 21км барьсны дараа гараанаас гарна.
  12-17 насны охид хөвгүүд 09:45 цагт гараанаас гарна.)
- ✓ Дуусах цэг: Сүхбаатарын талбай

## 8. ЗАМ ХААХ ЦАГ

- ✓ 42км195м-бүтэн марафон 05цаг30минутад багтана.

## 9. БҮРТГҮҮЛЭХ & БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ

**21км-н (35-54) (55+) насны мастеруудын ангиллын тамирчид 18-34 насны олон улсын тэмцээний ангилалд оролцож болно.**

*Хаах: 2019 оны 05 сарын 12 өдөр

Бүртгүүлэх: Вэб сайтаар бүртгүүлэх (http://ulaanbaatarmarathon.mn)
(Бүртгүүлсэн ч тэмцээнд хувийн шалтгаанаас оролцож чадаагүй тамирчид, иргэд, бүх оролцогчдод буцаан олгот олгохгүй. Зохион байгуулах хороо ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ болно.)

*Бүртгэлийн хураамж

2019 оны 05 сарын 18 хүртэл бүртгэнэ.

| Марафоны төрөл | Бүртгэлийн хураамж |
|---|---|
| 42км | 50000₮ |
| 21км | 50000₮ |
| 10км | 25000₮ |
| 5000м /эрүүл мэндийн гүйлт/ | 2000₮ |
| 1500м /хараагүй, тэргэнцэртэй/ | 2000₮ |
| 1500м /гэр бүлийн/ | Оролцогч бүр 2000₮ |

*Банкны мэдээлэл /зөвхөн монгол оролцогчид/

- Банкны нэр: Худалдаа Хөгжлийн Банк
- Дансны нэр: Монголын Хэт Холын Марафон Гүйлтийн Холбоо НҮТББ
- Банкны дугаар (MNT): 499139195

Гүйлгээний утга дээр нь овгийн эхний үсэгтэй өөрийн нэр, уралдах зай төрөл, утасны дугаараа бичнэ үү:

**Г. Маралмаа 21км 88559816**

Төлбөрийн тушаасан баримтаа доорх мэйл хаягаар илгээнэ үү. info@ulaanbaatarmarathon.mn

## 10. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

СЭРГЭЛТИЙН ЦЭГ

Тэмцээний замын 5км тутамд сэргэлтийн цэг байрлана. Нэг нь дотоодын тамирчдад, нөгөөх нь гадаадын тамирчдад зориулагдсан цэг байршина. Оролцогчид зөвхөн сэргэлтийн цэгээс ус авна. Сэргэлтийн цэгээс бусдаар замаас ус болон ямар нэгэн бүтээгдэхүүн авсан бол тэмцээнээс хасагдана. 10км-н тойрог замаар явна.

## 11. ШАГНАЛ

Тэмцээний шагналын мөнгө MNT:

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хагас марафон | 10км | | |

| Байр /эр,эм/ | Бүтэн марафон | 18-34 /олон улсын/ | 35-54 /дотоод/ | 55+ /дотоод/ | | 1500м /хараагүй, тэргэнцэртэй болон гэр бүлийн/ | 5км /12-17 нас/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| I | 10000000 | 5000000 | 500000 | 500000 | 500000 | 200000 | 200000 |
| II | 8000000 | 4000000 | 400000 | 400000 | 400000 | 150000 | 150000 |
| III | 6000000 | 3000000 | 300000 | 300000 | 300000 | 50000 | 100000 |
| IV-X | 800000-4000000 | 200000-400000 | 100000-200000 | 100000-200000 | 100000-200000 | | IV-VIII байр 50000 |

*5км нээлттэй тэмцээнд шагнал байхгүй.

| Эр, Эм | Бүтэн марафон | Хагас марафон | 10км | 5км /12-17нас/ |
|---|---|---|---|---|
| Медаль /1-3 байр/ | + | + | + | + |
| Өргөмжлөл /1-3 байр/ | + | + | + | + |
| Цом /1-3 байр/ | + | + | + | |
| Дурсгалын медаль /зам хаах цагтаа багтаж замаа дуусгасан 42км195м-н бүх тамирчид/ | + | | | |

*Тэмцээний 1-3 байрын ялагчид тэмцээний дараа допингийн шинжилгээнд сугалаагаар хамрагдана. Шинжилгээний хариуг харгалзан, тэмцээний дараа 3 сарын дотор шагналын мөнгийг тухайн оролцогчийн данс руу нь олгоно.

**Тэмцээний өдөр явагдах үзэсгэлэн экспо, асар худалдаанаас УБ Марафоны лого эмблемтэй өөр загварын дурсгалын зүйлсийг худалдаж авах боломжтой.

## 12. ТЭМЦЭЭНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

- 2019.05.15.Даваа гараг
  Бүх оролцогчдод энгэрийн дугаар болон бусад дагалдах зүйлсийг тарааж эхэлнэ.

- 2019.05.17.Баасан гараг
  18:00 цагт Техникийн зөвлөгөөн
  /монголын болон гадаадын бүх тамирчид цугларах/
  /Байршлыг тэмцээний энгэрийн дугаар олгох үеэр зарлана./

- 2019.05.18.Бямба гараг
  09:30 цагт Нээлт
  10:00 цагт Тэмцээн эхлэх (Марафоны бүх төрлүүд зэрэг эхэлнэ)
  15:00 цагт Шагнал гардуулж эхлэх

Тэмцээн болох өдрийн өглөө 08:00 цагаас эхлээд Улаанбаатар хотод автобус, автомашин явахгүй учир оролцогчид та бүхэн өглөө гэрээсээ гарах цагаа сайтар төлөвлөнө үү. Тэмцээний эхлэх цагаас хоцорсон бол тэмцээнээс хасагдахыг анхаарна уу.

## 13. АВЧРАХ ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС /ЦАГ АГААРААС ШАЛТГААЛАН/

- ✓ Борооны цув /бороо орсон үед/
- ✓ Гүйлтийн хувцас
- ✓ Нарны шил
- ✓ Салхинаас хамгаалах гадуур хувцас

## 14. ДҮРЭМ

A. Хасагдах журам
Дараах үйлдлүүдээс нэгийг л гаргавал тухайн оролцогч тэмцээнээс хасагдана:

- Ямар нэгэн дугуй скит гэх мэт тээврийн хэрэгсэл ашигласан
- Тэмцээнд хамааралгүй хүнээс тусламж авсан, түрүүлэх, хөтлөх, чирүүлсэн тохиолдолд
- Сэргэлтийн цэгээс бус, гаднаас ус ундаа авсан
- Бүх төрлийн хориглох сэргээш, эмийн бүтээгдэхүүн хэрэглэсэн
- Mp3, гар утас гэх мэт бүх төрлийн чихэвч сонссон тохиолдолд (зам тээврийн осол гарах, хүнтэй мөргөлдөх эрсдэлтэй учир)
- Тэмцээнийг замын дундаас орхисон тохиолдолд

- Хэрүүл маргаан гаргасан тохиолдолд
- Зохион байгуулагчдын зааврыг үл дагасан тохиолдолд (оролцогчдын аюулгүй байдлын төлөө)

B. Зам хаах цаг
Зам хаах цаг 05цаг30минитад багтаж барианд ороогүй тохиолдолд тэмцээнээс хасагдана. (Энгэрийн дугаар буцаагдаж, тэмцээнээс хасагдана.)

C. Энгэрийн дугааргүй, чипгүй тамирчдыг барианд барихгүй.

**D. 21км-н (35-54) (55+) насны мастеруудын ангиллын тамирчид 18-34 насны олон улсын тэмцээний ангилалд оролцож болно.**

## 15. ДААТГАЛ

Энэхүү тэмцээн нь оролцогчдод ямар нэгэн даатгалын үйлчилгээ үзүүлэхгүй болно. Бүх оролцогчид тэмцээний өмнө, амь насаа өөрсдөө хариуцахаа мэдэгдсэн мэдэгдэлтэй уншиж танилцан гарын үсгээ зурж баталгаажуулах.

## 16. ХУВИЙН ЭД ЗҮЙЛСЭЭ ХАДГАЛУУЛАХ

Бүх оролцогчид тэмцээний зохион байгуулах хорооноос бэлдэж өгсөн тусгай газар өөрсдийн эд зүйлсийг аюулгүй хадгалуулах болно.

### *Соёлын төв өргөө*

Оролцогчид өөрсдийн эд зүйлсээ үлдээхдээ, энгэрийн дугаар, гар утасныхаа дугаарыг зориулалтын уутан дээрээ заавал бичиж үлдээн буцааж авахдаа хувь хүний энгэрийн дугаараар олгоно.

Үнэт эд зүйлс, утас гэх мэт зүйлсээ үлдээхгүй байхыг анхаарна уу.

## 17. ЦАГ АГААР

Олон жилийн дундаж:
2016 /+20 градус/
2017 /+10 градус, бороо орсон/
2018 /+18 градус/
2019

## 18. САНАМЖ & АНХААРУУЛГА

**Утас: 976-7000-9809**
**info@ulaanbaatarmarathon.mn**
www.ulaanbaatarmarathon.mn
**Монголын үндэсний олимпийн хороо, 1 давхар, 110 тоот**

- ✓ Бүртгэлийн хураамж болон аяллын багцын захиалгын төлбөрийг 04 сарын 28 өдрөөс хойш буцаан олгохгүй болно.
- ✓ Энгэрийн дугаар нэг оролцогчид зөвхөн нэг л удаа олгогдох бөгөөд энгэрийн дугаарыг өөрчлөх, шилжүүлэх хориотойг хатуу анхаарна уу.
- ✓ Оролцогчид өөрсдийн эрүүл гэдгийг батлсан эмчийн бичигтэй тэмцээнд оролцоно.
- ✓ **21км-н (35-54) (55+) насны мастеруудын ангиллын тамирчид 18-34 насны олон улсын тэмцээний ангилалд оролцож болно.**

## 19. <u>НЭМЭЛТ АЯЛЛЫН БАГЦ /зөвхөн гадаадын оролцогчдод/</u>

## 20. <u>ТЭМЦЭЭНИЙ ГАЗРЫН ЗУРАГ</u>

Дараах зурагнууд нь 2018 оных тул энэ жил жижиг өөрчлөлт орж болно.



# Улаанбаатар Олон Улсын Марафон 2019

## 10 КМ ГҮЙЛТИЙН ЗАМЫН МАРШРУТ




## БҮТЭН МАРАФОН 42 КМ 195М ГҮЙЛТИЙН ЗАМЫН МАРШРУТ (4 ТОЙРОГ)




**Утас: 976-7000-9809**
**info@ulaanbaatarmarathon.mn**
www.ulaanbaatarmarathon.mn
**Монголын үндэсний олимпийн хороо, 1 давхар, 110 тоот**